



ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ, ЗУУЧЛАГЧИД ШИМТГЭЛ ОЛГОХ ЖУРАМ
ПДЖ-СБА-11(04)

УЛААНБААТАР ХОТ
2025 он

[illegible]

	“ПРАКТИКАЛ ДААТГАЛ” ХХК-ИЙН ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ, ЗУУЧЛАГЧИД ШИМТГЭЛ ОЛГОХ ЖУРАМ	Батлагдсан огноо: 2025.06.25	
		Мөрдөж эхлэх: 2025.07.01	
		Код: ПДЖ-ЗХНХ	Хуудас: 8
Хариуцагч:	Санхүү удирдлагын газар		
Саналаа тусгасан:	Гүйцэтгэх захирал	Н.Түмэндэмбэрэл	
	Санхүү хариуцсан захирал	Б. Бямбасайхан	
	Байгууллагын борлуулалт хариуцсан захирал	М. Алтайбаатар	
	Бизнес хөгжил даатгалын бодлого хариуцсан захирал	Э. Өрлөгболд	
	Иргэдийн борлуулалт хариуцсан захирал	Т. Дэнсмаа	
	Нөхөн төлбөр хариуцсан захирал	Ц. Батцэнгэл	
Боловсруулсан:	Конплейнс хариуцсан менежер	М. Замбагацэцэг	
	Бизнес хөгжлийн мэргэжилтэн	Б. Оюунбилэг	

АГУУЛГА

- | | |
|-----------|--------------------------------|
| 1. Зүйл 1 | Нийтлэг үндэслэл |
| 2. Зүйл 2 | Нэр томьёоны тодорхойлолт |
| 3. Зүйл 3 | Даатгалын төлөөлөгчийн шимтгэл |
| 4. Зүйл 4 | Даатгалын зуучлагчийн хөлс |
| 5. Зүйл 5 | Тайлагнал, хариуцлага |

ХАВСРАЛТ

- | | |
|----------------|-------------------------|
| 1. Хавсралт №1 | Шимтгэл олгох зөвшөөрөл |
|----------------|-------------------------|

БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Н.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Даатгалын төлөөлөгч, зуучлагчид шимтгэл олгох журам (цаашид “журам” гэх) нь Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Даатгалын багц дүрэм” болон бусад холбогдох хууль, тогтоомжид үндэслэсэн “Практикал даатгал” ХХК (цаашид “компани” гэх)-ийн баримт бичиг болно.
- 1.2. Журмын зорилго нь компанитай хамтран ажилладаг даатгалын төлөөлөгч, зуучлагчид даатгалын хураамжийн орлогоос шимтгэл тооцоолон олгох харилцааг зохицуулахад оршино.
- 1.3. Журамд өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай асуудлыг Борлуулалтын чиг үүрэг хариуцсан нэгж, Санхүү удирдлагын газар болон Гүйцэтгэх захирлын саналыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.
- 1.4. Энэхүү журмыг Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлах бөгөөд баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Дор дурдсан нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 2.1.1. “даатгалын үйл ажиллагаа” гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг;
 - 2.1.2. “даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа” гэж даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу түүний ашиг сонирхлын төлөө хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үйл ажиллагаа;
 - 2.1.3. “даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа” гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх үйл ажиллагааг;
 - 2.1.4. “даатгалын зуучлалын хөлс” гэж даатгалын зуучлагч болон даатгалын төлөөлөгчид даатгал зуучилсны төлөө олгох хөлс;
 - 2.1.5. “даатгалын төлөөлөгч” гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх үүрэг бүхий даатгагчийн томилсон буюу эрх олгосон этгээдийг;
 - 2.1.6. “даатгалын зуучлагч” гэж даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах хуулийн этгээд, хувь хүн;
 - 2.1.7. “борлуулалт хариуцсан захирлууд” гэж компанийн бүтээгдэхүүний борлуулалтыг зохион байгуулах үүргийг шууд хариуцаж буй газар, нэгжийн шууд удирдлагыг.

ГУРАВ. ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ШИМТГЭЛ

- 3.1. Компанийн борлуулалт хариуцсан захирлууд, орон нутаг салбар хариуцсан захирлууд Санхүүгийн зохицуулах хорооноос эрх авсан даатгалын төлөөлөгчтэй гэрээ байгуулж хамтран ажиллана.
- 3.2. Хариуцсан борлуулалт хариуцсан нэгжийн ажилтан, салбарын захирлууд төлөөлөгчийн хувийн хэрэг, хамтран ажиллах гэрээ, олгосон шимтгэлийн баримт мэдээллийг архивлан хадгална.
- 3.3. Даатгалын төлөөлөгч, зуучлалын шимтгэлийг
 - 3.3.1 даатгалын бүтээгдэхүүн, стратегийн ач холбогдол
 - 3.3.2 харилцагчийн хураамжийн хэмжээ,
 - 3.3.3 харилцагч болон бүтээгдэхүүний хохирлын харьцаа
 - 3.3.4 даатгалын төлөөлөгчийн ажилласан жил, ажлын туршлага, борлуулалтын хэмжээ хамааруулан ялгаатай тогтоож болно.

3.4. Даатгалын төлөөлөгч, зуучлалын шимтгэл нь бүтээгдэхүүний төрөл бүрээр дараах хувь хэмжээтэй байна. Үүнд:

№	Бүтээгдэхүүний төрөл	Даатгалын төлөөлөгчийн шимтгэлийн хувь хэмжээ
1	Тээврийн хэрэгслийн даатгал	20%
2	Жолоочийн хариуцлагын даатгал	
3	Гадаадад зорчигчийн даатгал	
4	Малын индексжүүлсэн даатгал	
5	Хөрөнгийн даатгал	
6	Хариуцлагын даатгал	
7	Эрүүл мэндийн даатгал	
8	Бусад даатгал	

- 3.5. Төлөөлөгчтэй гэрээ байгуулахаар тохиролцох үед даатгалын төлөөлөгчийн шимтгэлийг журмын 3.4-т заасан “шимтгэлийн хувиас” шалтгаалан дараах байдлаар шийднэ. Үүнд:
- 3.5.1 Даатгалын төлөөлөгчийн шимтгэл нь журмын 3.4-т заасан хэмжээнээс хэтрээгүй тохиолдолд борлуулалт хариуцсан нэгжийг хариуцсан захиралтайгаа зөвшилцөж Санхүү удирдлагын газрын захирлын зөвшөөрлөөр олгоно.
- 3.5.2 Даатгалын төлөөлөгчийн шимтгэл нь журмын 3.4-т заасан хэмжээнээс давсан тохиолдолд Гүйцэтгэх захирлаар батлуулж Санхүү удирдлагын газар хянаж олгоно.
- 3.6. Онцгой тохиолдолд төлөөлөгч, зуучлалын шимтгэлийн хэмжээг журмын 3.4 т зааснаас өөрөөр тогтоож болох бөгөөд энэ тохиолдолд журмын 3.5.2-т заасан процессын дагуу олгоно.
- 3.7. Төлөөлөгчтэй гэрээ байгуулагдахаас өмнө хамтран ажиллаж байгаа борлуулалтын ажилтан ХАВСРАЛТ №1 заасан загвараар журмын 3.5-т заасны дагуу зөвшөөрөл авна.
- 3.8. Даатгалын гэрээ сунгагдан үргэлжлүүлэн даатгагдаж байгаа харилцагчийн өмнөх жилийн нөхөн төлбөрийн мэдээллээс хохирлын харьцаа компанийн босго харьцаанаас дээш байвал төлөөлөгчийн шимтгэлийн хэмжээг бууруулж журмын 3.4-т зааснаас хэтрүүлэхгүй байхаар мөрдөнө.
- 3.9. Төлөөлөгчийн шимтгэлийн хэмжээг өмнөх жилийнхээс бууруулан гэрээ байгуулсан тохиолдолд хариуцсан борлуулалтын ажилтанд багасгасан үнийн дүнгийн 10 хүртэлх хувийн борлуулалтыг урамшууллыг олгоно. Уг урамшууллыг Гүйцэтгэх захирлын шийдвэрийг үндэслэнэ.
- 3.10. Төлөөлөгчийн шимтгэлийн хэмжээг журмын 3.9-т зааснаар бууруулсан тохиолдолд хамтын ажиллагааны хөтөлбөрт зориулж бууруулсан шимтгэлийн үнийн дүнгийн 40 хүртэлх хувийг Гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр зарцуулж болно.
- 3.11. Энэ журмын 3.10-т заасан хамтын ажиллагаанд зарцуулж болох мөнгөн дүн нь хамгийн ихдээ 10 сая төгрөг байна.
- 3.12. Даатгалын төлөөлөгч нь хувь хүн бол олгох шимтгэлээс хуулийн дагуу Хувь хүний орлогын албан татвар суутгасны дараа төлөөлөгчийн арилжааны банк дахь дансанд шилжүүлэн олгоно.
- 3.13. Даатгалын төлөөлөгч нь хуулийн этгээд бол нэхэмжлэлийг үндэслэн төлөөлөгчийн арилжааны банк дахь харилцах дансанд шилжүүлж олгоно.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИЙН ХӨЛС

- 4.1. Эрх бүхий даатгалын зуучлагчтай анх гэрээ байгуулах үед даатгалын төрлөөс хамааруулан шимтгэлийн хувь хэмжээг тохиролцон гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдөнө.

- 4.2. Даатгалын гэрээ дараагийн жилд сунгагдан ажиллах үед даатгалын гэрээний хохирлын харьцаа дунджаас дээш бол зуучлагчтай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу даатгалын зуучлалын хөлсийг журмын 3.4-т заасан хувиас хэтрүүлэхгүй мөрдөнө.
- 4.3. Даатгалын зуучлалын шимтгэл нь журмын 3.4-т заасан хэмжээнээс давсан тохиолдолд Гүйцэтгэх захирлаар батлуулж Санхүү удирдлагын газар хянаж олгоно.
- 4.4. Даатгалын зуучлагчид олгох зуучлалын хөлсийг зуучлагчтай хийсэн тооцоо нийлэлт, түүний бүртгэлийг үндэслэн харилцах дансанд шилжүүлнэ.
- 4.5. Даатгалын зуучлагчид олгох зуучлалын хөлсний тооцоог хариуцсан борлуулалтын ажилтан сар бүр хийж даатгалын зуучлагчийн нэхэмжлэхийг Санхүү удирдлагын газарт хүлээлгэн өгнө.

ТАВ. ТАЙЛАГНАЛ, ХАРИУЦЛАГА

- 5.1. Улирал бүрийн дараа сарын 15-ны дотор хариуцсан борлуулалтын ажилтан, хариуцсан төлөөлөгч, зуучлагч бүрээр даатгалын хураамжийн орлого, үнэлгээ, шимтгэлийн дүнг харуулсан мэдээг Даатгалын багц дүрмийн 10-р хавсралт даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан мэдээ, өргөдөл гаргах зааврын 14-р хавсралтын дагуу гаргаж Санхүү удирдлагын газарт хүлээлгэн өгнө.
- 5.2. Даатгагч буюу Практикал Даатгал ХХК-ийн Санхүү удирдлагын газар “Даатгалын багц дүрмийн 10-р хавсралт даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан мэдээ, өргөдөл гаргах зааврын 14-р хавсралт”-ын дагуу улирал бүр санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгад төлөөлөгч, зуучлагчид олгосон шимтгэлийг тайлагнана.
- 5.3. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааны тухайн жилийн нийлбэр орлого нь 20.0 (хорин) сая төгрөг ба түүнээс дээш хэмжээтэй бол даатгалын төлөөлөгч өөрийн орлогын тайлангаа “Даатгалын багц дүрэм”ийн 10 дугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын холбогдох хавсралтын дагуу төлөөлж буй компанидаа мөн журамд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээнэ.
- 5.4. Даатгагч нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, хувьцаат компани, гадаадын хөрөнгө оруулалттай компанитай гэрээ байгуулсных нь төлөө даатгалын төлөөлөгчид олгосон төлбөр хөлс, даатгуулагч, даатгалын гэрээний талаарх мэдээллийг улирал бүр өөрийн цахим хуудсанд олон нийтэд ил тод зарлан мэдээлэх үүрэг хүлээнэ.
- 5.5. Энэхүү журмын хэрэгжүүлэлтийг борлуулалт хариуцсан нэгж, хяналтыг санхүү удирдлагын газар, комплайнс хариуцсан менежер хариуцан ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд холбогдох ажилтнууд компанийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээнэ.

“Даатгалын төлөөлөгч, зуучлагчид
шимтгэл олгох журам”-ын Хавсралт №01

ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ШИМТГЭЛ ОЛГОХ ЗӨВШӨӨРӨЛ

№	Байгууллагын нэр	Даатгалын төрөл	Даатгалын хураамжийн хэмжээ	Шимтгэлийн хувь	Шимтгэлийн хувь нэмэгдэх шалтгаан	Төлөөлөгчийн нэр	Хохирол нөхөлтийн харьцаа
1							
2							
3							

Боловсруулсан *Борлуулалтын мэргэжилтэн* / Гарын үсэг /

Зөвшөөрсөн: *Борлуулалт хариуцсан нэгжийг хариуцсан захирал* / Гарын үсэг /

Зөвшөөрсөн: *Гүйцэтгэх захирал* / Гарын үсэг /

Зөвшөөрсөн: *Санхүү удирдлагын газрын захирал* / Гарын үсэг /